



Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ
ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын 2025 оны
06 дугаар сарын 14-ны өдрийн
дугаар тушаалын хавсралт

ЦДҮС ТӨХК-ИЙН ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ АЖЛЫН ХЭСГИЙН 2025-2026 ОНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Эрчим хүчний салбарын жендэрийн үйл ажиллагааны зорилго, зорилт /ЭХЯ-ны дэргэдэх жендэрийн салбар зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөө/	ЦДҮС ТӨХК-ийн жендэрийн ажлын хэсгийн үйл ажиллагааны төлөвлөгөө	Шалгуур үзүүлэлт	Төсөв	Хугацаа	Хариуцах ажилтан
Нэг. Компанийн удирдлага, ажилтан, албан хаагчдад жендэрийн эрх тэгш байдлын мэдлэг, чадвар, хандлагыг төлөвшүүлж, жендэрийн хэвшмэл үзлийг өөрчлөх цогц үйл ажиллагааг						
1.1.	Эрчим хүчний салбарын байгууллагуудын жендэрийн өнөөгийн байдал, ЖЭТБ хэрхэн хангагдаж байгаа талаар судалгаа хийх	Компанийн жендэрийн өнөөгийн байдал, ЖЭТБ хэрхэн хангагдаж байгаа талаар судалгаа хийх	Судалгаанд хамрагдсан хэлтэс, салбарууд, болон ажилтнуудын тоо	-	2025 оны 3-4-р улиралд 2026 оны 3-4-р улиралд	Ажлын хэсгийн гишүүд: Б.Солонго, М.Доржханд
1.2.	ЖЭТБ-ыг хангах тухай хуулийн талаарх мэдээллийг дотоод сүлжээ болон хэвлэлд нийтлэх	"ЖЭТБ-ыг хангах тухай хууль"-ийн талаарх мэдээллүүдийг бэлтгэн компанийн вэб сайт, төв удирдлага, салбаруудын фэйсбүүк групп, "Дамжуулах сүлжээ" сонинд байршуулах	Байршуулсан мэдээллийн тоо	-	2025.08-р сард 2025.10-р сард 2025.12-р сард 2026.02-р сард 2026.04-р сард 2026.06-р сард 2026.08-р сард 2026.10-р сард 2026.12-р сард	Ажлын хэсгийн гишүүн Б.Солонго
1.3.	Салбарын төрийн ба хувийн хэвшлийн ААНБ-ын удирдах албан тушаалтан, ажилтан, албан хаагчдад зориулсан жендэрийн сургалтын хөтөлбөр, сургалтын материал боловсруулах	ЦДҮС ТӨХК-ийн удирдах албан тушаалтан, ажилтан, албан хаагчдад зориулсан жендэрийн сургалтын хөтөлбөр, сургалтын материал боловсруулах	Боловсруулсан сургалтын хөтөлбөр, сургалтын материалын нэр, тоо	-	2025 оны 4-р улиралд	Ажлын хэсгийн гишүүн М.Доржханд
1.4.	Салбарын төрийн ба хувийн хэвшлийн ААНБ-ын ажилтан, албан хаагчдад зориулсан жендэрийн мэдрэмжтэй сургалтыг зохион байгуулах	ЦДҮС ТӨХК-ийн удирдах албан тушаалтан, ажилтан, албан хаагчдад зориулсан жендэрийн мэдрэмжтэй сургалтыг зохион байгуулах. /ТУ, УБС, ХБС, ТБС, ЗӨБС, ГБС-т зохион байгуулах/	Зохион байгуулсан сургалтын тоо	ТУ 500.000 УБС 500.000 ХБС 500.000 ТБС 500.000 ЗӨБС 500.000 ГБС 500.000 АУЭХС 500.000 ББЭХС 500.000 Нийт 4.000.000	2026.01-р сард 2026.03-р сард 2026.05-р сард 2026.07-р сард 2026.09-р сард 2026.11-р сард	Ажлын хэсгийн ахлагч Я.Баттогтох, гишүүн Б.Солонго, М.Доржханд

Хоёр. Компанийн жендэрийн эрх тэгш байдлыг хангах бүтэц, тогтолцоог бэхжүүлж, хууль тогтоомж, бодлого төлөвлөлт, төсөвлөлт, хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээнд жендэрийн үзэл баримтлалыг нэвтрүүлэх

2.1.	Төрийн өмчит болон хувийн хэвшлийн ААНБ-д жендэрийн асуудал хариуцсан ажилтан томилох тухай удирдамж чиглэл хүргүүлэх /МУ-н Ерөнхий сайд, Жендэрийн үндэсний хорооны даргын 2025.02.04-ний өдрийн Жендэрийн үндэсний хорооны хуралдааны тогтоол №3-н дагуу/	Компанийн жендэрийн асуудал хариуцсан ажилтанг Гүйцэтгэх захирлын тушаалаар томилон ажиллуулах эсвэл хавсран ажиллуулж, хавсран ажилласны нэмэгдэл олгох тухай санал оруулах, батлуулах	Жендэрийн асуудал хариуцсан ажилтанг томилсон тухай ГЗ-ын тушаал	-	2025 оны 2-3-р улиралд	Ажлын хэсгийн ахлагч Я.Баттогтох
2.2.	Эрчим хүчний салбарын төрийн болон хувийн хэвшлийн ААНБ-ын дотоод журам болон хамтын гэрээнд ЖЭТБ-ын тухай тусгуулах	Компанийн дотоод журам, хамтын гэрээнд ЖЭТБ-ын тухай тусгуулах	Компанийн дотоод журам, эсвэл хамтын гэрээнд ЖЭТБ-ын тухай тусгасан байдал	-	2025-2026 онд	Ажлын хэсгийн ахлагч Я.Баттогтох, гишүүн Б.Солонго, М.Доржханд

Гурав. Компанийн ажилтанд жендэрийн ялгаатай хэрэгцээнд нийцсэн, ажил-ар гэрийн амьдралын тэнцвэрийг хангасан орчин нөхцөл бүрдүүлэх, эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд тэгш үр шим хүртэхэд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх

3.1.	Хөдөлмөрийн хортой, хүнд нөхцөлд ажиллаж буй эрэгтэй, эмэгтэй ажилтнуудын дундаж наслалтын судалгаа гаргах	Хөдөлмөрийн хортой, хүнд нөхцөлд ажиллаж буй эрэгтэй, эмэгтэй ажилтнуудын дундаж наслалтын судалгаа гаргах	Төв удирдлага, салбаруудад хийгдсэн судалгаа	-	2025 оны 3-4-р улиралд	Ажлын хэсгийн гишүүд: Б.Солонго, М.Доржханд
3.2.	Хортой, хүнд нөхцөлд ажиллаж буй эрэгтэй, эмэгтэй ажилтнуудын дундаж наслалтад нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлж дүгнэлт гаргах	Хөдөлмөрийн хортой, хүнд нөхцөлд ажиллаж буй эрэгтэй, эмэгтэй ажилтнуудын дундаж наслалтад нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлж дүгнэлт гаргах	Гаргасан дүгнэлт	-	2025 оны 3-4-р улиралд	Ажлын хэсгийн гишүүн М.Доржханд
3.3.	Эрчим хүчний салбарын байгууллагын дотоод журамд ЖЭТБ тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуулиар ажил олгогчид ногдуулсан үүргийн хэрэгжилтийг хангуулах талаарх заалтыг тусгах	Компанийн дотоод журам болон хамтын гэрээнд ЖЭТБ тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуулиар ажил олгогчид ногдуулсан үүргийн хэрэгжилтийг хангуулах тухай заалтыг хэлтэс, салбаруудаас санал авч нэгтгэн тусгуулах ажлыг зохион байгуулах	Компанийн дотоод журам болон хамтын гэрээнд ЖЭТБ-ын тухай тусгуулсан байдал	-	2025-2026 он	Ажлын хэсгийн ахлагч Я.Баттогтох, гишүүн Б.Солонго, М.Доржханд
3.4.	-	Хөгжлийн бэрхшээлтэй ажилтан, хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүнээ асран халамжилдаг ажилтнуудад тулгамдаж буй асуудлын талаар тэдгээр ажилтнуудтай ярилцлага хийх, дүгнэлт гаргах /ажилтнуудын өөрсдийн хүсэлтийг харгалзан ярилцах/	Ярилцлагад хамрагдсан ажилтны тоо	-	2025 оны 3-4-р улиралд	Ажлын хэсгийн гишүүн Б.Солонго
3.5.	-	Хөгжлийн бэрхшээлтэй ажилтан, хөгжлийн бэрхшээлтэй гэр бүрийн гишүүнээ асран халамжилдаг ажилтан, жирэмсэн, хөхүүл эмэгтэй, цэцэрлэгийн болон сургуулийн бага ангийн хүүхэдтэй ажилтнуудын өглөө ажилдаа ирэх, орой ажлаас тарах цагийг уян хатан байдлаар зохицуулах, мөн ажилтанд хүүхдийнх нь төрсөн өдрөөр болон "School police" хийсэн өдөр цалинтай чөлөө олгох, эдгээр асуудлыг хөдөлмөрийн дотоод журам, хамтын гэрээнд тусгуулах, хэрэгжилтийг хангуулах	Хамтын гэрээ, дотоод журамд тусгасан байдал	-	2025 онд 2026 онд	Ажлын хэсгийн ахлагч Я.Баттогтох, гишүүн Б.Солонго

Дөрөв. Компанийн жирэмсэн, хөхүүл эмэгтэй, бага насны хүүхэдтэй эрэгтэй, эмэгтэй ажилтан, ажил үүргийн хувьд зайнаас ажиллах боломжтой ажилтанд уян хатан ажлын цагаар болон зайнаас ажиллах боломж бүрдүүлэх талаар Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах сайн туршлага нэвтрүүлэх

4.1.	Эрчим хүчний салбарын ААНБ-ын дотоод журам болон цаг бүртгэлийн журамд жирэмсэн, хөхүүл эмэгтэй, бага насны хүүхэдтэй эрэгтэй, эмэгтэй ажилтан, ажил үүргийн хувьд зайнаас ажиллах боломжтой ажилтанд ажлын цагийн уян хатан нөхцөлийг бүрдүүлэх	Компанийн дотоод журам, хамтын гэрээнд жирэмсэн, хөхүүл эмэгтэй, бага насны хүүхэдтэй эрэгтэй, эмэгтэй ажилтан, ажил үүргийн хувьд зайнаас ажиллах боломжтой ажилтанд ажлын цагийн уян хатан нөхцөлийг бүрдүүлэх	Хамтын гэрээ, дотоод журамд тусгасан байдал	-	2025-2026 он	Ажлын хэсгийн ахлагч Я.Баттогтох, гишүүн Б.Солонго, М.Доржханд
4.2.	Салбарын ААНБ-ын дэргэд хүүхдийн цэцэрлэг, өдөр өнжүүлэх ажиллуулах боломжийг судалж, хэрэгжүүлнэ.	Төв удирдлага болон салбаруудын төв оффист ажилтнуудын хүүхдүүдэд зориулсан "Хүүхдийн өрөө" байгуулах, тус өрөөний үйл ажиллагааг хүүхдүүдийг нас, сэтгэхүйн онцлогт тохируулан хөтөлбөр гарган зохион байгуулах	Байгуулсан "Хүүхдийн өрөө"-ний тоо	Компанийн захиргаа, Үйлдвэрчний эвлэлийн хороодууд, ажилтнуудын хандив дэмжлэгээр	2025 онд 2026 онд	Ажлын хэсгийн ахлагч Я.Баттогтох, гишүүн Б.Солонго, М.Доржханд, Эцэг эхийн зөвлөлүүдтэй хамтран ажиллах

Тав. Бусад ажил

5.1.	-	ЭХЯ-ны дэргэдэх жендэрийн ажлын хэсэгт компаниа төлөөлөн ажиллах, тус ажлын хэсгээс өгсөн үүрэг даалгаварыг биелүүлэх, жендэрийн сургалтад хамрагдах, жендэрийн тухай мэдлэгээ дээшлүүлэх, энэ чиглэлээр хэрэгжүүлж болох арга хэмжээний талаар гадна, дотны байгууллагуудаас туршлага судалж, оновчтой арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах	ЖЭТБ-ын талаар хийж хэрэгжүүлсэн ажлууд	-	2025 - 2026 онд	Ажлын хэсгийн ахлагч Я.Баттогтох, гишүүн Б.Солонго, М.Доржханд
5.2.	-	Эрчим хүчний салбарт жендэрийн эрх тэгш байдлыг хангах стратеги төлөвлөгөөг (2023-2032) хэрэгжүүлэх бодлого боловсруулахад оролцох, /ЭХЯ-ны дэргэдэх ажлын хэсэгт оролцож ажиллах./	Батлагдсан бодлого	-	2025 онд	Ажлын хэсгийн ахлагч Я.Баттогтох, гишүүн Б.Солонго, М.Доржханд
5.3.	-	Эрчим хүчний салбарт жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтын журам боловсруулахад оролцох	Батлагдсан журам	-	2025 онд	Ажлын хэсгийн ахлагч Я.Баттогтох, гишүүн Б.Солонго, М.Доржханд

5.4.	-	Эрчим хүчний салбарын үйлдвэр, компаниудад зохион байгуулах сургалтын хөтөлбөр, материал боловсруулах ажилд оролцох. Үүнд: - "Жендэрийн статистик үзүүлэлтүүд ба мэдээллүүд /Монгол улсын эрчим хүчний салбарт/ бэлтгэх" - Б.Солонго - "Жендэрийн эрх тэгш байдлын тухай ойлголтын анхан шатны судалгааны асуумжийн маягт бэлтгэх" - Б.Солонго - "Жендэрийн тухай ойлголт (хэвшмэл ойлголт) сургалтын материал бэлтгэх" - М.Доржханд - "Төрөөс хэрэгжүүлж буй эрх зүйн орчинг эрчим хүчний салбартай уялдуулах" сургалтын материал бэлтгэх - М.Доржханд	Боловсруулсан материалын нэр, тоо	-	2025 оны 3-р улиралд	Ажлын хэсгийн гишүүд: Б.Солонго, М.Доржханд
5.5.	-	Компанийн хэмжээнд зохион байгуулагдах жендэрийн сургалтын зардлыг 2026 болон 2027 оны бизнес төлөвлөгөөнд тусгуулж, батлуулах	Батлагдсан төсөв	-	2025 оны 3-р улиралд 2026 оны 3-р улиралд	Ажлын хэсгийн ахлагч Я.Баттогтох, гишүүн Б.Солонго, М.Доржханд
5.6.	-	Компанийн нийт ажилтнуудаас "сэтгэл ханамжийн судалгаа" авах, дүгнэлт гаргах, тайлагнах	Гаргасан судалгаа, дүгнэлт	-	2025 оны 11-р сард 2026 оны 11-р сард	Ажлын хэсгийн ахлагч Я.Баттогтох, гишүүн Б.Солонго, М.Доржханд
5.7.	-	Компанийн жендэрийн ажлын тайланг компанийн удирдлагад тайлагнах, тайланг заасан хугацаанд ЭХЯ-нд хүргүүлэх	Хэрэгжилтийн хувь	-	2026 оны 01-р сард 2026 оны 07-р сард 2027 оны 01-р сард	Ажлын хэсгийн ахлагч Я.Баттогтох, гишүүн Б.Солонго, М.Доржханд

ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ХЭЛТЭС